



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД  
НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ НЬ

2024.00.00

Улаанбаатар хот

Нэхэмжлэгч: Оршин суугаа газрын хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, утасны дугаар

Хариуцагч: Оршин суугаа газрын хаяг, ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, утасны дугаар /хуулийн этгээд бол оршин байгаа газрын хаяг/

Нэхэмжлэлийн шаардлага: **Ажлын хөлс 150.000 төгрөг гаргуулах тухай**

Би 0000 оны 00 сарын 00-ны өдөр Ширмэн ХХК-ийн авто худалдааны төвд үйлчлэгчээр ажиллахаар тохиролцож, хөлсөөр ажиллах гэрээг компанийн захирал Доржтой байгуулсан.

Миний бие авто худалдааны төвийн 1 дүгээр давхарын цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцан 0000 оны 00 сарын 00 өдрөөс 0000 оны 00 сарын 00-ны өдөр хүртэл нийт 15 өдрийн ажиллахад цалин хөлс гэж 150.000 төгрөг өгсөн. Гэрээгээр тохиролцсоноор ажлын хөлс 1 өдрийн 10.000 төгрөг байсан. Гэтэл 2 дугаар давхарын цэвэрлэгч ажлаас гарсан тул 0000 оны 00 сарын 00-ны өдрөөс 0000 оны 00 сарын 00 өдөр хүртэл 15 өдөр худалдааны төвийн 1 болон 2 дугаар давхарын цэвэрлэгч ганцаараа хийсэн. Гэтэл цалин олгох өдөр надад цалин 150.000 төгрөг өгсөн.

Анх надтай хөлсөөр ажиллах гэрээг байгуулахдаа зөвхөн 1 дүгээр давхарын цэвэрлэгээг хариуцана гэж тохиролцсон бөгөөд 2 дугаар давхарын цэвэрлэгээг хийлгэхдээ цалинг 2 өдрөөр тооцон олгоно гэж хэлж байсан. Би худалдааны төвийн 1 болон 2 дугаар давхарыг цэвэрлэхэд өглөө 8 цагаас оройн 6 цаг хүртэл зогсоо зайгүй хөдөлмөрлөдөг байсан. Гэтэл миний хөдөлмөрийг үнэгүйдүүлж, ажлын хөлсийг минь шударгаар үнэлэхгүй байгаад туйлийн гомдолтой байна.

Иймд миний Ширмэн ХХК-ийн авто худалдааны төвийн 2 дугаар давхарыг хариуцан цэвэрлэгээ хийсэн 15 өдрийн цалин 150.000 төгрөгийг гаргуулах нэхэмжлэлийн шаардлага гаргаж байгааг хүлээн авч, шийдвэрлэж өгнө үү.

Нэхэмжлэлд хавсаргасан баримтууд:

1. Миний иргэний үнэмлэхийн нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, 1 ширхэг, 1 хуудас
2. Хөлсөөр ажиллах гэрээ нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, 1 ширхэг, 2 хуудас
3. Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлүүлэх тухай хүсэлт 1 хуудас

Улсын тэмдэгтийн хураамжийг Татварын ерөнхий газрын itax.mta.mn сайтаас төлбөрийн даалгавар үүсгэж, дурын банкны салбарт тушаах эсхүл шүүхийн байранд байршуулсан Gegece системийн өөртөө үйлчлэх төхөөрөмжөөр банкны карт ашиглан төлөх боломжтой.

Нэхэмжлэл гаргасан:

Нэр ... гарын үсэг ... гарын үсгийн тайлал